



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар #/31

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт, 35.11 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 226 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1541 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 57,630,300,000 (тавин долоон тэрбум зургаан зуун гучин сая гурван зуун мянга) төгрөгийн 50,000,000,000 (тавин тэрбум) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “121”-т заасан “Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар)”-ийн хөрөнгөөс, 7,630,300,000 (долоон тэрбум зургаан зуун гучин сая гурван зуун мянга) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын “1.86”-т заасан “Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар)”-ын хөрөнгөөс тус тус гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий

1725020205

болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханганд ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартувшинд даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1288 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 10-ны өдрийн
A/31.84.001 захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар)	2025	2025	57,630.3	57,630.3
ДҮН				57,630.3	57,630.3



مختصر در میراث اسلامی

۰۰ نتایجی ممکن است در محدوده این را تضمین کند و محدودیتی نداشته باشد. این نتایجی ممکن است در محدوده این را تضمین کند و محدودیتی نداشته باشد.

رسانیده اند و نیز در آنها میتوانند این روش را برای تحریر متن از زبان اصلی خود استفاده کنند. این روش معمولاً در متن‌هایی که دارای تکرارها و اصطلاحات متعددی هستند، بسیار مفید است. مثلاً اگر متنی را که شامل مواردی می‌شود که در آنها اصطلاحاتی باشند که شما ممکن است با آنها آشنا نباشید، می‌توانید این اصطلاحات را با کلماتی که شما آشنا باشید جایگزین کنید. این روش ممکن است در متن‌هایی که دارای تکرارها و اصطلاحات متعددی هستند، بسیار مفید است. مثلاً اگر متنی را که شامل مواردی می‌شود که در آنها اصطلاحاتی باشند که شما ممکن است با آنها آشنا نباشید، می‌توانید این اصطلاحات را با کلماتی که شما آشنا باشید جایگزین کنید.

